

## Шинэхэн буриадын хуримын дууны яруу найргийн зарим онцлог

Сарангэрэл

(Төвийн Үндэстний Их Сургууль)

**Abstract:** The Buryats originally resided in the Russian Federation around Lake Baikal and at the beginning of the 20th century they migrated to Hulun Buir known as “Shinehen Buryats”, who settled on the bank of River Xinihe. There are over 6000 Buryats who are settling in three countries: Russia, Mongolia and China. The history of Shinehen Buryats is relatively short, but their ways of living, rituals and languages are no longer same to each other. It is surprising that they preserved their traditional culture such as ritual of wedding ceremony especially the tradition of wedding songs. In this paper, the author tries to examine the history of wedding songs of the Shinehen Buryats in China and their rituals and the peculiarities of the wedding song poems’ contents, meanings and expressions.

**Keywords:** Shinehen Buryats, wedding ceremony, wedding song poem, poem peculiarity.

**Товч утга:** XX зууны эхээр Буриадчууд Оросоос Хүлэн Буйр нутагт уван цуван нүүдэллэн ирж, Шинэхэн голын хөвөө даган нутагшиж, “Шинэхэн Буриад” хэмээх нэрээр алдаршиж зуун жилийн түүхтэй болоод байна<sup>1</sup>. Энэ улмаас Оросын Буриад, Монгол улсын Буриад, Хятад улсын Шинэхэн Буриад гэж Буриадчууд ихэвчлэн гурван улс оронд тархан аж төрөх болсон байна. Энэхүү түүхэн хугацаанд аж амьдралын хэлбэр, зан заншил, хэл яриа зэрэг олон талаар ялгаа зөрүү гарсан байна. Гэвч төр хуримын зан үйл, ялангуяа төр хуримын дуу нь эрт дээдийн уламжлалаа алдаагүй шахам хадгалж уламжилсаар байгаа нь гайхалтай. Тус өгүүлэлд голдуу Хятад улсад байгаа Шинэхэн Буриадчуудын дунд уламжлагдаж байгаа Буриад ардын төр хуримын<sup>2</sup> дууны түүхэн ахуй, холбогдол бүхий зан заншил, агуулга, утга санаа ба хэл хэллэгийн онцлог зэргийг шинжлэхийг зорьсон юм аа.

**Түлхүүр үгс:** Шинэхэн Буриад, Хуримын дууны яруу найраг, онцлог

<sup>1</sup> Н.Насан-өлзий, Билиг нарын эмхэтгэн тайлбарласан “Буриадын түүхэн сурвалж бичиг”, ӨМСХХ, 1999 он, Будангууд Авидын туурвисан “Буриад монголын товч түүх”, 1983 он, Түвшинням, Авид нарын найруулан зохиосон “Хөлөн буйрын барга буриад, өөлдийн түүхэн ирэлт”, ӨМСХХ, 2013 он, Цогтын Жамц “Шинэхэн буриад монголчууд”, ӨМСХХ, 2013 он, О.Дулам “Шинэхэний мөр”, ӨМАХХ, 2012 он

<sup>2</sup> 2017.07.29 Цагангууд овогтой Толойд настныг сурвалжилсан тэмдэглэл, Толойд настан бол хулгана жилтэй 1948 онд төрсөн, нэрийн утга нь Гэрэлт гэсэн үг. Хуримыг “төр” гэдэг тухай миний асуусанд доорх тайлбар хийсэн, Буриадчууд ураг хуримыг “төр” гэх буюу “төр хурим” гэдэг. Энгийн яриан дундаа “төр бэлтгэх” гэвэл хуримын бэлтгэл хийх, “төрд орох” гэвэл хуримд оролцох гэсэн үг болно. Хурим нь ганц хувь хүний бус нийгэм нийт ба төр гүрний явдал гэж үздэгээс ингэж нэрлэжээ.

Ардын дуу бол ард түмний суу билиг, оюун ухааны бэлгэдэл, үндэсний түүх соёлын тэмдэглэл, хайр сэтгэлийн толь болох дээд зэргийн содон урлаг юм. Ардын дуу бол ард түмний амьдрал, аж байдлыг уран үг, уянга шүлгээр илэрхийлсэн байдаг. Буриад ардын төр хуримын дуунд ч тэдний ураг хуримын ёс заншил ба зан дадгал, аж байдал нь тусгагдсан төдийгүй хүн зоны хайр сэтгэл, хүсэл бодол ч нэвчсэн байдаг. Миний бие Буриад нутгаар урьд хожид олон удаа хээрийн шинжилгээ хийж, төр хуримын тухай, түүх соёл заншлын тухай янз бүрийн материал цуглуулж ардын аман түүхийг тэмдэглэж авсан юм. Түүний нэг хэсгийг нь энд нийтэлье.

Буриад Монголчууд түүхийн урт удаан хугацаанд төр хуримын соёл болсны бүрэн бүтэн цогцолборыг бүтээж, аажмаар хэвшүүлэн төгөлдөржүүлсэн байдаг. Үүнд басган зайх, басганы их наадам гэх мэт төр хуримын оршил гэлтэй сонирхолтой ёс заншил байдаг бөгөөд төр хуримын дуу гэдэг нь голдуу басганы их наадамд зориулсан шинжтэй байдаг. Тэдгээр дуу нь төр хуримын эл явцдаа зохицсон өөрийн онцлогтой, өөрийн хэв намбатай маш өвөрмөц утга агуулгатай, тодорхой зориулалттай төв ёсорхог өөд эсрэг бэлгэдлийн утгатай дуунууд байдаг.

### Нэг. Ууцны дуунууд

Буриад төр хуримын чухал нэг явц болох “Басганы их наадам”<sup>3</sup> нь ихэвчлэн гурван алхмаар явагдах бөгөөд алхам бүрт нь зориулсан ардын дуунууд байдаг юм. Тэр дотор “ууцны дуу” бол басганы их наадмын нэгдүгээр алхамд дуулах чухал дуу болно. Буриадчууд басганаа маш их хайрлан, мордохоос нь өмнө ах дүү саднаар нь тойруулан айлчлуулж, сайхан наадуулах бөгөөд тусгай басганы их наадам хийж, басганаа баярлуулж мордуулдаг байна. Их наадам дээр мордох болсон басганыхаа өмнө хонины ууц тавьж, хүндлэн зочлох юм. Тэр үед дуулдаг дууг ууцны дуу гэж нэрлэдэг. Хадамд мордох басган энэ их шөнийг ер бусын утга агуулгатай уйлж дуулж өнгөрөөдөг байна. Нэг талаар аав, ээж, ах, дүү оныхоо хайр хүндэтгэлийг хүртэж, сэтгэл тэнэгэр баярлаж, нөгөө талаар гэр нутгаасаа салж ядан уяран байж өнгөрөөдөг юм. Далимд нь тэмдэглэхэд, миний ажигласнаар басганы их наадам дээр хоёр нэр томьёо маш сонирхолтой байна. Нэг нь “өвгөн түрүү” хэмээх даамал, нөгөөдөх нь “басган нөхөр” хэмээх найз хүүхнүүд. Энэ хоёр нэр томьёоны эзэн нь бол басганы их наадмын гол дүрүүд юм. Гэрийн зүүн талаар суусан басгануудын дээд талд саатах “өвгөн түрүү” бол энэ оройн бүх наадмын ерөнхий захирагч, ёс заншлын хянан удирдагч юм. “Басган нөхөр” бол энэ оройн наадмын гол дүр болох харьд мордох басганы сэтгэлийн тэнхээ баясах гомдох өнгө бүрийн сэтгэлийг нь хуваалцах дотно

<sup>3</sup> 2017.07.25 Хөлөн буйр хотын Эвээнхи хошууны Шинэхэн Буриад Баруун сумын Нансалмаа настныг сурвалжилсан тэмдэглэл. 2017.07.26-ны орой Эвээнхи хошууны төв Баянтохой балгасанд “Басганы их наадамд” биесчлэн оролцож сурвалжилсан тэмдэглэл. Энгийн үед “Басганы их наадам” буюу “Басганы их найр” гэдэг энэ наадмын гол нь хуримын өмнө орой хийнэ. Уламжлалт басганы их наадамд хүргэний талыхан оролцохгүй гэтэл одоо бол хүргэн болон түүний найз нөхдүүд оролцдог болжээ. Хуучин цагт энэ наадам нь нар шингэхээс эхлэж, үүрийн туяагаар өндөрлөдөг байсан гэнэ.

түшиг нь болдог аж. Ингээд басганыхаа өмнө ууц тавих наадам эхлэхэд өвгөн түрүүгийн захиа заавраар наадамд ирсэн ахмад настан, үеийн найз нар ба аав ээж нь бүгдээр дуулалдан баясаж найрладаг. Настайчуудын дурсан ярихыг үндэслэвэл, дээр үед тэдгээр түр хуримын дуунд хавсаргах хөгжмийг залуу идэргүй өөртөө хөгжимдөж өөртөө дуулдаг байжээ. Тусгай урлагчид залах шаардлагагүй.<sup>4</sup> Энэ тухай ном сурвалжид ч буриадчуудад “хялгасан хуур”, “модон жимбүүр”, “хулсан лимбэ”, “арьсан хэц”, “хайлсан хэнгэрэг” зэрэг уламжлалт хөгжмийн зэмсэг байсан тухай тэмдэглэж байна.

Тэр үед дуулдаг ууцны дуу нь хадамд мордох басган ба цугларсан олон залуучууд багачуудад захиа сургаал болгох дуу болохоор буриадын түр хуримын дуу дотор чухал ач холбогдолтой бөгөөд өөр бусдаас ялгарах онцлогтой юм. Агуулгын талаар шашин төрөө магтсан, ахмад настнаа хүндлэх, харь хол мордохын ёс учрыг тайлбарлах зэрэг өргөн утга санааг агуулж байдаг. Тэдгээр ууцны дунд:

Арван зүгийг гийгүүлсэн  
 Алтан шар наран бий  
 Амьтан бүхнийг жаргуулдаг  
 Бурхан багшийн сургаал бий  
     Дөрвөн зүгийг гийгүүлсэн  
     Төгрөг шар нар бий  
     Түмэн амьтныг жаргуулдаг  
     Бурхан багшийн шашин бий гэж бурхан богд, шашин шүтээнээ  
 магтан эхэлж, залгаад  
 Төрийн олон түшмэдэд  
 Төөлэйн домог юу өргөө  
 Найрын олон түшмэдэд  
 Наадмын дуу юу өргөө<sup>6</sup> гэж төр гүрний тулгуур болсон сайд түшмэдээ дурсаж магтсан байдаг. Энэ мэт шашин төрийн тухай эхлээд басгандаа хандаж, залуучууддаа хандаж захиа сургуулийн агуулга бүхий дуугаа дуулна. Тэгээд дуунаас жишээлбэл:

<sup>4</sup> 2017.07.25 Хөлөн буйр хотын Эвээнхи хошууны Шинэхэн Буриад Баруун сумын Нансалмаа настныг сурвалжилсан тэмдэглэл. 2017.07.26-ны орой Эвээнхи хошууны төв Баянтохой балгасанд “Басганы их наадамд” биечлэн оролцож сурвалжилсан тэмдэглэл. Энгийн үед “Басганы их наадам” буюу “Басганы их найр” гэдэг энэ наадмын гол нь хуримын өмнө орой хийнэ. Уламжлалт басганы их наадамд хүргэний талыхан оролцохгүй гэтэл одоо бол хүргэн болон түүний найз нөхдүүд оролцдог болжээ. Хуучин цагт энэ наадам нь нар шингэхээс эхлэж, үүрийн туяагаар өндөрлөдөг байсан гэнэ.

<sup>5</sup> А.Бадамцэрэн найруулан зохиосон “Шинэхэн Буриад монголчуудын түүх ба соёл”, ӨМСХХ, 2014 он, 90-р тал.

<sup>6</sup> 2012.08.20 Хөлөн буйр хотын Эвээнхи хошууны Шинэхэн Буриад баруун сумын Лэгжима настныг сурвалжилсан тэмдэглэл

Оргилоо булгийн эхнээс  
 Ундлахын тухайдаа буугаарай  
 Орны хол очвоош еэ  
 Урд эртийн ёс юм хэ  
     Харгилаа булгийн эхнээс  
     Хазаарт морь юу услаарай  
     Харийн холыг зоривч еэ  
     Хамаг олны ёс л юм хэ

Ангир булгийн эхнээс  
 Үдлэхийн тухайдаа буугаарай  
 Энгүй холыг зоривоош еэ  
 Эрт л урьдын ёс юм хэ  
     Ардаг агсам морин чинь  
     Адуугаа гэж янцгаах л еэ  
     Айдар бахан бие чинь  
     Ээж юүгээ л санах чи еэ

Эмнэг агсам морин чинь  
 Ижлээ гэж янцгаах л еэ  
 Идэр багахан бие чинь  
 Ээж юүгээ л санах чи еэ  
     Өндөр уулын модондоо  
     Өнгийн шувууд донгодно  
     Өлгийдөө тэнзээсэн ээж чинь  
     Үр юү гэж л санах л еэ<sup>7</sup> гэх мэтээр дуулдаг.

Буриад төр хуримын ёсонд ууцны дуу чухал байр суурь эзэлдэг. Гэхдээ ууцны дууг төр хуримын аль ёслолын явцад дуулдаг тухай хувиралтай болсон гэдгийг сурвалжилгаар дамжин ойлголоо. Зарим настад ууцны дууг басганы их наадам дээр дуулдаг гэж ярьж байхад харин зарим настад айл өрх болж амьдралаа эхлүүлж байгаа их хурим дээр шинэ хүргэн, шинэ бэр хоёр шинэ хүнээ хүндийн суудалд залж, уламжлалт ёс заншлаараа цай хоол бэлтгэн ууц тавьж хүндлэх үед аав, ээж, ах, дүү, садан нарыг төлөөлсөн дуучид захиад сургаалиа хайрласан агуулга бүхий ууцны дуу дуулдаг гэж тайлбарлаж байв. Бас зарим настад ууц тавьсан үед дуулж байгаа болохоор “ууцны дуу” гэж нэрлэжээ. Басганы наадамд ч гэсэн, их хуримд ч гэсэн цөм ууц тавих ёслолын явц бүхэнд ууцны дуу дуулна гэж тайлбарлаж байна. Бас зарим настад өнгөрсөнд ууцны дууг зөвхөн басганы их наадам дээр дуулдаг байлаа, одоо бол хамаагүй дуулж байна гэхчлэн янз янзаар тайлбарлаж байна. Дээд монгол ардын дуунд найрын гурван дуу буюу төрийн гурван дуу, шашны гурван дуу гэж байдаг. Төр хуримын үед хүндийн суудалд төрийн түшиг хошуу ноён, сайд түшмэд нар саатаж байвал “төрийн гурван дуу”-гаар эхэлж, хүндийн суудалд гэгээн хутагт, лам хуварга саатаж байвал “шашны гурван дуу”-гаар эхэлж найр хуримаа сэргээдэг заншилтай байсан. Буриад төр хуримаас “ууцны дуу” гэдэг нь үүнтэй адил найрын тусгай

<sup>7</sup> “Буриад монгол ардын дуу”, ӨМСХХ, 1984 он

зориулалттай дуу байж, хуримын ёслолын явцаар нь нэрлэсэн шиг байна. Ууцны дууны агуулгаас үзэхэд найрын дуу, төр шашны дуу, захиа сургаалын дууны агуулга бүрэн гэж үзэж болно. Гэхдээ магтаалын аястай дуу цөөн шиг, харин сурган захисан, сануулсан, анхааруулсан шинжтэй дуу олон байдгаараа онцлогтой. Жишээлбэл, басганы их наадам дээр дуулж байгаа ууцны дуунд:

Алдхан шар зулаа  
 Бурхандаа бадраан мордоорой  
 Авралын дээд богдыгоо  
 Алдал үгүй шүтээрэй  
     Нарийхан шарга морио  
     Наадмынхаа дунд шаргаарай  
     Насан багахан биеэ  
     Наадмынхаа дуунд жаргаарай  
 Өндөрхөн шарга морио  
 Үдийнхээ наранд шаргаарай  
 Охин багахан биеэ  
 Ерөөлийнхөө дунд жаргаарай <sup>8</sup>гэх мэтээр дуулдаг.

Энд шашин шүтээн, бурхан богдоо магтан биширсэн төдий биш, харин яаж дахин хүндлэх тухай захин сургасан байна. Үүнээс гадна бас аав, ээж, ахас захсаа ачлан хүндлэх ёс, гийчин зочноо хүндлэн дайлах ёс заншил зэргийг сануулж захисан, басганыхаа аливаа сайн сайхныг хүсэн зөгнөсөн агуулгатай дуу ч байдаг.

Дуулах аргын талаар настайчуудыг сурвалжлах үед төр хуримын эдгээр дууг эрэгтэйчүүд хамтаар дуулж бүх гийчин түрж дуулдаг гэж хэлсэн боловч, бодит төр хурим дээр эмэгтэй, эрэгтэй бүгдээр хамтаар дуулж түрж байгаа байдал харагдаж байна.

### Хоёр. Нэргэлгийн дуунууд

Буриад төр хуримын басганы их наадмын хоёрдугаар алхам нь нэргэлгэ болно. Нэргэлгэ гэдэг нь буриад төр хуримын басганы их наадамд зориулсан бүжигний ая дуу гэж хэлж болно. Басганы их наадамд оролцох басган залуучууд ууцын найрын дараа гэрийн гадна гарч түдэг гал тойрон шөнөжин бүжиж наргих юм. Энэ наргианаа “нэргэлэх” гэж хэлэх буюу “нэргэлгэ” гэж нэрлэдэг юм. Үүнд дуулах дууг нэргэлгийн дуу гэж, бүжгийг нь нэргэлгийн бүжиг гэнэ. Нэргэлгийн бүжиг ба дууг тусгайлан басганы их наадамд бүжиглэж дуулдаг байна. Нэргэлгийн бүжигт нэргэх ба ээрэмших гэж хоёр зүйл байна. Нэргэх гэдэг нь нэргэлгийн дууны аялгууг дагаж, аажмаар ганхан зөөлөн бүжиглэх бүжиг болно. Жишээлбэл:

<sup>8</sup> 2017.07.26-ны орой Эвэнхи хошууны төв Баянтохой балгасанд “Басганы их наадамд” бичлэн оролцож сурвалжилсан тэмдэглэл (дүрс бичлэг)

Намжаахан өндрийн оройгоор  
Нарны туяа мандлаа  
Навтархан хөлтэй ширээнд  
Зулын туяа мандлаа

Талын чимэг дэрвэлж л шувуу  
Танарын чимэг дадмалхан шүр  
Уулын чимэг ууль л шувуу

Олны чимэг улаахан шүр гэх мэтээр дуулж аажим бүжиглэдэг.

Нэргэх бүжгийн алхац ба ёс журам нь тийм будилаантай биш. Олноороо түдэг тойрч гар гараа холбож, салхины аяар ганхах, хулсан хашаа мэт хоёр тийшээ ганхан найгаж бүжиглэнэ. Яг л нэргэлгийн дуунд дуулагдаж байгаа,

Нарийн голын бургас нь  
Наран тийшээ найгана  
Найман эцгийн ламбугай нар  
Дацан тийшээ найгана.

Хараа голын бургас нь  
Хажуу тийшээ найгана  
Хамниган эцгийн ламбугай нар  
Дацан тийшээ найгана<sup>9</sup> гэх мэт.

Ээрэмшээх бүжиг гэдэг нь мөн нэргэх бүжгээ залган, холбож барьсан гар гараа тавьж, хоёр гурваараа нэг баг болж араараа гар гараа нягт холбон дэвсэлдэн бүжиглэдэг гэж болно. Олонх байдалд хоёр хүн нэг баг болж эгэм зэрэгцүүлэн гар холбож хатиран бүжиглэнэ. Ээрэмшээх бүжгийн цохилго нь түргэн, алхац дэвсэц нь чанга басганы их наадамд ирсэн хөгшин залуу басган хөвгүүдгүй түдэг галыг тойрч хөнгөн шунган үсэрч харайн дуулалдан бүжиглэдэг байна.

Үүнээс гадна бас буриад төр хуримын бэхлэгийн дуу гэж басганы их наадмын гуравдугаар алхамд бэхлэг нууж наадах үед дуулдаг дуунууд байдаг. Бэхлэг гэдэг нь бэлзэг бөгжийг хэлж байна. Зарим насад бэхлэгийн дууг бэлзгийн дуу гэж нэрлэж байна<sup>10</sup>. Гадна түдэг галаа тойрч хуур хөгжөөнтэй дуулан бүжиглэн нэг хэсэг наадаад дахин гэрт орж, баруун зүүн хоёр баг болон сууж бэхлэг нууж наадна. Тэр үед бэхлэгийн дууг дуулдаг. Настайчуудын дурсан ярихыг үндэслэвэл уламжлалт бэхлэг нууж наадах наадамд хоёр багийн аль нь нуусан бэхлэгийг тааж олсонгүй бол дийлэгдсэнд тооцож бэхлэгийн дууг дуулна. Гэтэл одоо бараг хоёр баг хамтаар дуулдаг болсон гэнэ. Тусгай энэ наадамд зориулсан бэхлэгийн дуу гэж шог хошин маягийн дуу, нэг нэгнээ егөөдсөн агуулгатай дуу ч байсан гэнэ. Гэтэл одооны залуучууд бас шинэ шинэ зохиолын дуу ч хааяа дуулж байна гэж насад ярьж байна<sup>11</sup>. Бэхлэгийн дуу нэг ёсны тоглоом наадмын чанартай дуу болохоор шоглож егөөдсөн агуулгатай байдгийг жишээлбэл:

<sup>9</sup> Л.Эрдэнэчимэг, “Буриад хуримын зан үйл”, УБ хот, Удам соёл ХХК, 2014 он, 33-р тал

<sup>10</sup> 2017.07.26 Хөлөн буйр хотын Эвээнхи хошууны Шинэхэн Буриад Баруун сумын Хоосой настанг сурвалжилсан тэмдэглэл

<sup>11</sup> 2016.07.26 Хөлөн буйр хотын Эвээнхи хошууны Шинэхэн Буриад Баруун сумын Тэмээн хүзүү багийн Сүхбаатар настныг сурвалжилсан тэмдэглэл, гахай жилтэй, 1949 онд төрсөн Хоосой овогтой

Баруун нуурын бага шингэ  
 Бархиралдан цуугалдан байг аа  
 Даага идсэн боохой шингэ

Дэргэлдэн тургилдан байг аа<sup>12</sup> гэж бэхлэг нуух наадамд ялагдсан багийг хурдан дуулахыг шаардан шахамдуулж наргиан үүсдэг байна.

Буриадчууд “бах” гэж мэлхийг, “боохой” гэж чоныг нэрлэдэг. Хоёр баг болж хуваагдахыг бас хоёр “муж” болгох гэж хэлж байна. “Муж” гэдгийг настайчууд “баг, бүлэг, бүлгэм гэх утгатай. Хуучин цагт нэг овог ястны дотор ижил бэлчээрт малжиж, ойрхон яваа айлуудын нэг мужийхан гэдэг байлаа” гэж тайлбарлалаа. Буриадчуудын төр хуримын дууны шүлэгт гарч байгаа зарим сонирхолтой үг, нэр нэрийдлийн тухай тусгай өгүүлэл бичих болохоор энд товчилъё, “Хянган голын бялзуухай” гэдэг бэхлэг дуунд:

Хянган голын бялзуухай  
 Хялгандаа эндүүтэй  
 Хянаж бодож явахад  
 Орчлонд эндүүтэй  
 Найрын голын бялзуухай  
 Навчиндаа эндүүтэй  
 Нарийсган бодож явахад  
 Орчлонд эндүүтэй

Бодлын голын бялзуухай  
 Бургасандаа эндүүтэй  
 Бодож хянаж явахад  
 Орчлонд эндүүтэй<sup>13</sup> гэх мэтээр дуулдаг байна.

Бэхлэгийн дуу гэж их олон дуу байдаг байжээ. Настайчуудын хэлэхээр, бэхлэгийн дууг хоёр багаараа булаалдан наадаж тоглосоор үүрийн долон гарахад басганы хадамд мордох цаг болсон гэж зогсдог байсан гэнэ.

Буриад ардын төр хуримын ёсонд басганы их наадам гэх ёслол нь тэр хэвээрээ ардын дуу бүжгийн чуулга, дуулалт жүжгийн үзүүллэг, дуу бүжгийн их наадам, уралдаан байсан гэлтэй. Басганы их наадмын талбайд орсон бүхэн сэтгэл санаа сэргэж, цог жавхаа баяр баясгалантайгаар “хатирь ёохор” гэж

Тохмын чинээ газраа  
 Толоор болтол хатирья  
 Толгой дээрх сажаа  
 Хандир яндар хатирья<sup>14</sup> гэх мэтээр дуулж бүжиглэдэг.

Тэрхүү дуу бүжгийн гайхамшигт наадам нь буриад түмний басган үрээ харуусах, салж ядах олон өнгийн сэтгэлийг илтгэхийн хамт ихэвчлэн хоёр зүйлийн зориулалттай байсан байна.

Нэгд, басган үрээ ээж аав, ах дүү, садан найз нөхдөөсөө аяарлаж харь

<sup>12</sup> 2017.07.26-ны орой Эвээнхи хошууны төв Баянтохой балгасанд “Басганы их наадамд” биечлэн оролцож сурвалжилсан тэмдэглэл (дүрс бичлэг)

<sup>13</sup> Соёл. “Буриад ардын төр хуримын дууны тухай”, “Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан” сэтгүүл, 2012 оны хоёрдугаар хугацаа

<sup>14</sup> П.Хорлоо “Монгол ардын дууны яруу найраг”, ӨМСХХХ, 1989 он, 283-р тал

хол морьдохоос нь өмнө хайрлан хүндэлж, баярлуулан цэнгүүлж ханатал нь наадуулахыг зорьсон гэлтэй. Учир нь уламжлалт ёсоор бол басган нь өөр хал овгийн алс хол газар мордож хэдэн жил сараар гэр нутагтаа буцаж ирэх завшаан тун ховор байдаг байжээ. Тийм болохоор маргаашаас эхлэн хүний эхнэр, айлын бэр болж харь хол яваад дахин өөрийн нутагтаа, өөрийн дотны хайртай хүмүүстэйгээ ингэж наадан жаргах цаг завшаан ховор, цаашилбал нэг насандаа дахин тохиолдохгүй ч байж мэдэх ажээ.

Хоёрт, басган үрдээ захин сургаж, сануулан сэрэмжлүүлэх зорилготой байсан. Ээж аавынхаа гар дээр эрх дураараа байсан басган үрдээ харь хадамд хүрч ахмад настнаа хүндлэх, ачир үрээ хайрлах хадам дээдээ ачлах, хань ижлээ халамжлах зэрэг янз бүрийн хэв үйл, ёс заншлыг хэлж сургаж захихын хамт басганыхаа айл гэрийн аз жаргал аливаа сайн сайхныг зөгнөж ерөөх ёстой байжээ.

Буриад ардын төр хуримын дууг агуулга баялаг, төрөл зүйл олон, утга санаа гүн, үг хэл уран, орон нутгийн онцлог шинж бүхий байж, эрдэм шинжилгээний өргөн их нөөцтэй юм. Хөгжим судлалын үүднээс харж болох, ая дан, айзам хөг. Зан үйл зүйн үүднээс харах ёс заншил, ёслол үйл, дэг дүрэм. Хэл зүйн үүднээс харах заншил хэллэг, нутгийн аялга, үгсийн сан гэх мэт эрдэм шинжилгээний маш олон салбарт чанагш судлах хоосон зай үлдээсээр байна.